

БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



**САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Өлгий сумын Ерөнхий боловсролын 5 дугаар сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

**Аудитын код: БӨА-2022/126/НА-СТА-ТШЗ**

<p>Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Өлгий хот 2022 он</p>	<p>Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын дарга бөгөөд тэргүүлэх аудитор: М.Хуанган Утас: 70422954 Цахим хаяг: huanganm@audit.gov.mn Аудитын менежер: Х.Женисбек Утас: 70422930 Цахим хаяг: jenisbekh@audit.gov.mn “Уужим алтай Аудит” ХХК-ны аудитор: В.Хуандых Утас: 99426960 Цахим хаяг: khuash69@gmail.com</p>
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу. .

## Агуулга

---

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	6
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	8
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	9
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	11
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	13
3. Аудитын тайлан .....	15
3.1 Ерөнхий зүйл .....	15
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт .....	15
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	16
3.4 Материаллаг байдал .....	16
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга .....	16
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв .....	18
<b>3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг .....</b>	<b>19</b>
<b>3.8 Аудитын гол асуудал .....</b>	<b>19</b>
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	19
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .....	19
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	20
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	21
4. Аудитын илрүүлэлт .....	21
4.1 Залруулсан алдаа .....	21
4.2 Төлбөрийн акт .....	21
Байхгүй .....	21
4.3 Албан шаардлага .....	21
4.4 Зөвлөмж .....	21
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл .....	22

**Товчилсон үгийн жагсаалт**

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт



**БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

83129 Өлгий, Баян-Өлгий аймаг,  
Утас/Факс: (976) 7042-2954  
E-mail: bayanulgii@audit.gov.mn

**ӨЛГИЙ СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН  
5 ДУГААР СУРГУУЛИЙН  
ЗАХИРАЛ Ж.РОЗА ТАНАА**

᠒᠐᠒᠒.᠐᠒.᠒᠒ № ᠑᠑  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

**АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ**

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Өлгий сумын Ерөнхий боловсролын 5 дугаар сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/ өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Өлгий сумын Ерөнхий боловсролын 5 дугаар сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн одог улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Ulgii+EBS+5-dugnelt

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  М.ХУАНГАН



Ulgii+EBS+5-dugnelt

## 2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

			Төгрөгөөр
Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>98,444,575.00</u></b>	<b><u>116,473,603.00</u></b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	-	-
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	2,167,162.00	15,000,000.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	2,167,162.00	-
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	-	15,000,000.00
3351	Байгууллагаас авах авлага	-	15,000,000.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	96,277,413.00	101,473,603.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	96,277,413.00	101,473,603.00
35410	Бичиг хэргийн материал	13,931,172.00	14,880,353.00
35420	Аж ахуйн материал	19,254,119.00	25,013,019.00
35440	Түлш, шатах тослох материал	3,274,950.00	-
35470	Бусад хангамжийн материал	59,817,172.00	61,580,231.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>4,265,344,183.50</u></b>	<b><u>4,171,472,739.34</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	4,265,344,183.50	4,171,472,739.34
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	4,147,756,183.50	4,053,884,739.34
39201	Барилга, байгууламж, орон сууц	4,036,232,226.14	4,036,232,226.14
39202	Хуримтлагдсан элэгдэл	(139,878,745.84)	(209,742,918.76)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	319,376,781.00	317,889,449.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(177,266,148.75)	(196,068,461.99)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	189,734,446.20	194,972,522.20
39208	Хуримтлагдсан элэгдэл	(115,616,931.25)	(132,577,201.25)
39217	Ном	35,174,556.00	43,179,124.00
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	117,588,000.00	117,588,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	118,138,000.00	118,138,000.00

39304	Хуримтлагдсан элэгдэл	(550,000.00)	(550,000.00)
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>4,363,788,758.50</u></b>	<b><u>4,287,946,342.34</u></b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>-</b>	<b>-</b>
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>4,363,788,758.50</u></b>	<b><u>4,287,946,342.34</u></b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	4,363,788,758.50	4,287,946,342.34
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	842,334,698.00	842,334,698.00
51101	Өмч: - төрийн	842,334,698.00	842,334,698.00
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	(3,991,410.39)	(79,833,826.55)
51210	Өмнөх үеийн үр дүн	(3,991,410.39)	(3,991,410.39)
51220	Тайлант үеийн үр дүн	-	(75,842,416.16)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	3,525,445,470.89	3,525,445,470.89
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b><u>4,363,788,758.50</u></b>	<b><u>4,287,946,342.34</u></b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>2,698,803,317.20</b>	<b>2,616,166,816.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	-	<b>1,535,564.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	-	1,535,564.00
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	-	1,535,564.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	-	1,535,564.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>2,698,803,317.20</b>	<b>2,614,631,252.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	2,604,399,379.20	2,526,936,706.00
131005	Хөрөнгийн санхүүжилт	78,700,179.20	15,404,906.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	2,525,699,200.00	2,511,531,800.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	6,770,838.00	17,261,446.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	500,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,000,000.00	12,252,980.00

131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	5,770,838.00	4,508,466.00
131106	Төсвийн урамшуулал	-	-
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	87,633,100.00	70,433,100.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	87,633,100.00	70,433,100.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>2,740,456,683.59</b>	<b>2,691,997,119.66</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>2,740,456,683.59</b>	<b>2,691,997,119.66</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	2,648,457,507.59	2,594,148,481.66
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	2,133,005,553.00	2,093,769,891.00
210101	Үндсэн цалин	1,889,976,085.36	1,959,426,319.00
210104	Урамшуулал	215,802,767.64	134,343,572.00
210105	Гэрээт ажлын хөлс	27,226,700.00	-
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	267,172,069.00	271,269,933.00
210201	Тэтгэврийн даатгал	181,676,999.00	192,030,054.00
210202	Тэтгэмжийн даатгал	17,099,012.00	19,809,870.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	21,373,766.00	15,848,036.00
210204	Ажилгүйдлийн даатгал	4,274,754.00	3,962,033.00
210205	Эрүүл мэндийн даатгал	42,747,538.00	39,619,940.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	88,053,134.00	71,641,139.00
210301	Гэрэл, цахилгаан	5,983,995.00	4,533,100.00
210302	Түлш, халаалт	82,069,139.00	67,108,039.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	14,996,128.00	17,384,640.00
210401	Бичиг хэрэг	12,071,520.00	12,393,940.00
210402	Тээвэр, шатахуун		631,500.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,903,108.00	3,250,700.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	900,000.00	350,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	121,500.00	758,500.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	3,040,245.00	1,377,600.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл		30,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,040,245.00	1,347,600.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	15,847,374.00	14,516,246.00

210604	Урсгал засвар	15,847,374.00	14,516,246.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	170,000.00	418,000.00
210702	Дотоод албан томилолт	170,000.00	418,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	126,173,004.59	123,771,032.66
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,863,190.00	7,706,795.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	121,309,814.59	116,064,237.66
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	91,999,176.00	97,848,638.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	49,333,000.00	83,884,200.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	49,333,000.00	83,884,200.00
<b>2135</b>	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	42,666,176.00	13,964,438.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	42,666,176.00	13,964,438.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>(41,653,366.39)</b>	<b>(75,830,303.66)</b>
<b>145</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН</b>	-	-
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	-	12,112.50
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	-	12,112.50
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	-	(12,112.50)
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>(41,653,366.39)</b>	<b>(75,842,416.16)</b>

### 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Төгрөгөөр
				Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	842,334,698.00	3,525,445,470.89	-3,991,410.39	4,363,788,758.50
2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	842,334,698.00	3,525,445,470.89	-3,991,410.39	4,363,788,758.50
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			580,914.00	580,914.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	842,334,698.00	3,525,445,470.89	-3,410,496.39	4,364,369,672.50
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт		-580,914.00		-580,914.00
Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт				0.00
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				0.00

Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү				0.00
Тайлант үеийн үр дүн			-75,842,416.16	-75,842,416.16
<b>2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>842,334,698.00</b>	<b>3,524,864,556.89</b>	<b>-79,252,912.55</b>	<b>4,287,946,342.34</b>

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

				Төгрөгөөр
Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл	
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>			
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>2,620,103,138.00</b>	<b>2,599,226,346.00</b>	
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>2,620,103,138.00</b>	<b>2,599,226,346.00</b>	
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	2,525,699,200.00	2,511,531,800.00	
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	2,525,699,200.00	2,511,531,800.00	
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	6,770,838.00	17,261,446.00	
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		500,000.00	
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,000,000.00	12,252,980.00	
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	5,770,838.00	4,508,466.00	
131106	Төсвийн урамшуулал			
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	87,633,100.00	70,433,100.00	
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	87,633,100.00	70,433,100.00	
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>2,620,103,138.00</b>	<b>2,592,426,346.00</b>	
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>2,620,103,138.00</b>	<b>2,592,426,346.00</b>	
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>2,528,103,962.00</b>	<b>2,494,057,208.00</b>	
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	2,108,436,100.00	2,081,994,362.00	
210101	Үндсэн цалин	1,865,393,400.00	1,909,849,662.00	
210104	Урамшуулал	215,816,000.00	134,708,000.00	
210105	Гэрээт ажлын хөлс	27,226,700.00	37,436,700.00	
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	284,666,500.00	280,859,500.00	

210201	Тэтгэврийн даатгал	200,320,900.00	197,641,900.00
210202	Тэтгэмжийн даатгал	21,086,400.00	20,804,400.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	16,869,100.00	16,643,500.00
210204	Ажилгүйдлийн даатгал	4,217,300.00	4,160,800.00
210205	Эрүүл мэндийн даатгал	42,172,800.00	41,608,900.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	88,797,924.00	68,933,100.00
210301	Гэрэл, цахилгаан	6,697,924.00	4,533,100.00
210302	Түлш, халаалт	82,100,000.00	64,400,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	20,474,200.00	12,502,700.00
210401	Бичиг хэрэг	3,592,600.00	1,162,000.00
210402	Тээвэр, шатахуун	2,795,000.00	1,050,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,670,000.00	3,250,700.00
210404	Ном, хэвлэл	2,351,600.00	2,656,100.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	900,000.00	350,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	8,165,000.00	4,033,900.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	7,838,400.00	3,801,500.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	489,900.00	481,400.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	7,348,500.00	3,320,100.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>		- 16,500,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл		15,000,000.00
210604	Урсгал засвар		- 1,500,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	170,000.00	418,000.00
210702	Дотоод албан томилолт	170,000.00	418,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	36,000.00	1,660,100.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	36,000.00	1,660,100.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	17,684,838.00	27,387,946.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	17,684,838.00	27,387,946.00

213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	91,999,176.00	98,369,138.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	49,333,000.00	84,404,700.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	49,333,000.00	84,404,700.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	42,666,176.00	13,964,438.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	42,666,176.00	13,964,438.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	-	6,800,000.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	-	6,800,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	6,800,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	-	6,800,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал		6,800,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-	(6,800,000.00)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Төгрөгөөр

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,581,964,900.00	2,568,000,462.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,581,964,900.00	2,568,000,462.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,484,652,400.00	2,483,595,762.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,082,141,000.00	2,081,994,362.00
210101	Үндсэн цалин	1,909,996,300.00	1,909,849,662.00
210104	Урамшуулал	134,708,000.00	134,708,000.00
210105	Гэрээт ажлын хөлс	37,436,700.00	37,436,700.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	280,859,500.00	280,859,500.00

210201	Тэтгэврийн даатгал	197,641,900.00	197,641,900.00
210202	Тэтгэмжийн даатгал	20,804,400.00	20,804,400.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	16,643,500.00	16,643,500.00
210204	Ажилгүйдлийн даатгал	4,160,800.00	4,160,800.00
210205	Эрүүл мэндийн даатгал	41,608,900.00	41,608,900.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	68,933,100.00	68,933,100.00
210301	Гэрэл, цахилгаан	4,533,100.00	4,533,100.00
210302	Түлш, халаалт	64,400,000.00	64,400,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	12,152,700.00	12,152,700.00
210401	Бичиг хэрэг	1,162,000.00	1,162,000.00
210402	Тээвэр, шатахуун	1,050,000.00	1,050,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,250,700.00	3,250,700.00
210404	Ном, хэвлэл	2,656,100.00	2,656,100.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,033,900.00	4,033,900.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	3,801,500.00	3,801,500.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	481,400.00	481,400.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,320,100.00	3,320,100.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	19,500,000.00	19,500,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	18,000,000.00	18,000,000.00
210604	Урсгал засвар	1,500,000.00	1,500,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	1,328,000.00	418,000.00
210702	Дотоод албан томилолт	1,328,000.00	418,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	1,660,100.00	1,660,100.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,660,100.00	1,660,100.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	14,276,500.00	14,276,500.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	14,276,500.00	14,276,500.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	97,312,500.00	84,404,700.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	97,312,500.00	84,404,700.00

213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	97,312,500.00	84,404,700.00
<b>13</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	2,581,964,900.00	2,568,000,462.00
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	2,511,531,800.00	2,497,567,362.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	2,511,531,800.00	2,497,567,362.00
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	70,433,100.00	70,433,100.00
132001	Орон нутгийн төсвөөс	70,433,100.00	70,433,100.00
<b>4</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		
<b>5</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>		
<b>6</b>	<b>ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ</b>		
<b>61</b>	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	1	1
610001	Төсвийн байгууллага	1	1
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	161	164
620001	Удирдах ажилтан	6	6
620002	Гүйцэтгэх ажилтан	120	123
620003	Үйлчлэх ажилтан	26	26
620004	Гэрээт ажилтан	9	9
<b>63</b>	<b>СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)</b>	2,345	2,345
<b>630</b>	<b>ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИД</b>	2,345	2,345
630001	Төрийн өмчит ЕБС	2,345	2,345
630002	Хувийн ЕБС		
<b>65</b>	<b>ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ</b>	<b>161</b>	<b>164</b>
650004	СЭБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД)	126	129
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	26	26
650010	Гэрээт ажилтан	9	9

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>17,261,446.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>17,261,446.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	17,261,446.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	350,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	350,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	3,800,000.00

210601	Багаж, техник, хэрэгсэл	3,800,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>13,111,446.00</b>
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	13,111,446.00
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>17,261,446.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>17,261,446.00</b>
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	500,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	12,252,980.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	4,508,466.00
<b>IV</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)</b>	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	

### **3. Аудитын тайлан**

#### **3.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Өлгий сумын Ерөнхий боловсролын 5 дугаар сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Сургуулийн нягтлан бодох бүртгэл хөтлөлт, тайлагналтай холбоотой зөвлөмжийг энэ тайланд тусган болно.

Аудитыг “Уужим алтай Аудит” ХХК-ны аудитор В.Хуандых гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Женисбек, дарга, тэргүүлэх аудитор М.Хуанган нар хэрэгжүүлсэн.

Өлгий сумын Ерөнхий боловсролын 5 дугаар сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 13 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

#### **3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт**

Байгууллагын зорилго, зорилт, үйл ажиллагааны чиглэл

Өлгий сумын Ерөнхий боловсролын 5 дугаар сургууль нь ерөнхий боловсрол олгох чиг үүргийг хэрэгжүүлдэг. Тус сургууль нь 2021 оны хичээлийн жилд "Суралцагчийн сурлагын хоцрогдлыг нөхөж, бие даан сурах үйлийг дэмжихэд бүх талын оролцоог ханган, сургалтын үйл ажиллагааг үр дүнтэй зохион байгуулах" зорилготой ажиллаж, дараах үндсэн 5 дэд зорилтыг дэвшүүлэн ажилласан байна. Үүнд:

- 1.Багш бүр хоцрогдлыг арилгах тусгай төлөвлөгөө гарган, эцэг эх асран хамгаалагчтай нягт холбоотой гурвалсан гэрээ байгуулан ажиллах
- 2.Дижитал технологийг хичээл сургалтын үйл ажиллагааны үндсэн хэрэгсэл болгон хөгжүүлэх, түүнийг үр дүнтэй ашиглахад багш нарын үйл ажиллагааг чиглүүлж, багш ажлын байрандаа тасралтгүй хөгжих боломжийг бүрдүүлэх
- 3.Суралцагчдын бие даан ажиллах дасгал, даалгаврын цахим сан бүрдүүлэх
- 4.Бага ангийн үдийн хоол хөтөлбөрийг мэргэжлийн байгууллагуудтай хамтран чанартай зохион байгуулах
- 5.Байгууллагын багш ажилтанууд шат шатандаа ажил үүрэгтээ хариуцлагатай хандаж ажлын байранд эерэг уур амьсгал бүхий байгууллагын соёл бүрдүүлэх
- 6.Ахлах, дунд ангид хичээл ордог багш нар суралцагчдад ажил мэргэжлийн чиг баримжаатай болох мэргэжлээ зөв сонгоход дэмжлэг үзүүлэх

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил

гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын алба нь аймгийн Төсвийн ерөнхийлөгчийн харъяа орон нутгийн төсөвт байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт шалгалт хийдэг.

Өлгий сумын Ерөнхий боловсролын 5 дугаар сургуульд 2021 онд Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба шалгалт хийгээгүй байна. Мэргэжлийн хяналтын газар багш ажилчдын нийгмийн даатгалын болон хуучин хөдөлмөрийн дэвтэрээр улсад нийт ажилласан жилийг тогтоож, цалин тогтоолтой тулган баталгаажуулж шалгалт хийсэн ба зөрчил илрээгүй байна

Сургууль дотоод хяналтын нэгжтэй ба захирлын тушаалаар батлагдсан журам, зааврын дагуу төлөвлөгөөт дотоод хяналт шалгалт хийдэг байна.

Тус сургуулийн дотоод хяналтын талаар ойлголт олж авснаар туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Өлгий сумын Ерөнхий боловсролын 5 дугаар сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### **3.4 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдлийг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 2,740.4 сая төгрөгөөс 1 хувиар буюу 27.4 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 21.9 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### **3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга**

Өлгий сумын Ерөнхий боловсролын 5 дугаар сургуулийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 75.8 сая төгрөгөөр буюу

1.7 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0.00	0.00	0.00
Авлага	2,167.2	15,000.0	12,832.8
Урьдчилгаа	0.0	0.0	0.00
Бараа материал	96,277.4	101,473.6	5,196.2
Үндсэн хөрөнгө	4,265,344.2	4,171,472.7	(93,871.4)
<b>Нийт хөрөнгө</b>	<b>4,363,788.7</b>	<b>4,287,946.3</b>	<b>(75,842.4)</b>
Өр төлбөр	0.00	0.00	0.00
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	4,363,788.8	4,287,946.3	(75,842.4)
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>4,363,788.7</b>	<b>4,287,946.3</b>	<b>(75,842.4)</b>

Мөнгөн хөрөнгийн данс оны эхэн ба эцэст үлдэгдэлгүй байна.

Авлага данс оны эцэст 15.0 сая төгрөг болж 12.8 сая төгрөгөөр нэмэгдсэн байна. Оны эхэнд нийгмийн даатгалын шимтгэл болон хувь хүний орлогын албан татварын 2.2 сая төгрөгийн авлагатай байсныг барагдуулж, аймгийн Засаг даргын 2021 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн А/1075 дугаартай захирамжаар сургууль, цэцэрлэгүүдийн төсвийн хэмнэлтээс төсөвт хийсэн зохицуулалтаар “Багшийн хөгжлийн танхим” ажиллуулахад зориулж тоног төхөөрөмж, техник хэрэгсэл худалдан авахад гэрээний дагуу 15.0 сая төгрөг шилжүүлж авлага үүсгэсэн байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 101.5 сая төгрөг болж 5.2 сая төгрөгөөр нэмэгдсэн байна. Тайлант онд 1.5 сая төгрөгийн бараа материалыг үнэ төлбөргүй хандиваар, 88.4 сая төгрөгийн бараа материалыг төсвийн хөрөнгөөр худалдан авч үйл ажиллагаандаа 84.7 сая төгрөгийн бараа материал зарцуулсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 4,171.5 сая төгрөг болж 93.8 сая төгрөгөөр буурсан нь төсвийн хөрөнгөөр худалдаж авсан 6.8 сая, хөрөнгийн санхүүжилтээр орлогод авсан 15.4 сая буюу нийт 22.2 сая төгрөгөөр нэмэгдэж, 10.4 сая төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга эд, хогшлыг акталж, үндсэн хөрөнгөнд 116.1 сая төгрөгийн элэгдэл байгуулсантай холбоотой байна.

Өр төлбөр данс оны эхэн ба эцэст үлдэгдэлгүй байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 4,287.9 сая төгрөг болж 75.8 сая төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүн 75.8 сая төгрөг гарснаас шалтгаалжээ.

Санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого 2,616.2 сая төгрөг байгаа нь өмнөх оноос 82.6 сая төгрөгөөр буюу 3.1 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан үнэ төлбөргүй орлого, урсгал санхүүжилт, нэмэлт санхүүжилтийн орлого байна. Урсгал санхүүжилт болон хөрөнгийн санхүүжилт буурсан байна.

Нийт зардал өмнөх оноос 48.4 мянган төгрөгөөр буюу 1.7 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан цалин, байр ашиглахтай холбоотой тогтмол зардал болон нормативт зардлууд байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар тайлант онд хөрөнгө акталсантай холбоотой, дахин үнэлгээний зөрүүгээр 0.5 сая төгрөгийн нягтлан бодох бүртгэлийн залруулга гарсан байна.

### **3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.6.1 Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2020 оны анх батлагдсан төсөв 2,410.6 сая төгрөг, тодотгосон төсөв 2,581.9 сая төгрөг байна.

Тодотгосон төлөвлөгөө нь анх баталсан төлөвлөгөөнөөс 171.4 сая төгрөгөөр нэмэгдсэн байна. Үүнд: Цалингийн зардлыг 194.8 сая, нийгмийн даатгалын шимтгэлийг 26.1 сая, эд хошгил, урсгал засварын зардлыг 18.0 сая, нийт 238.9 сая төгрөгөөр нэмэгдүүлж, хоол, хүнсний зардлыг анх баталсан төсвөөс 67.5 сая төгрөгөөр бууруулж нийт дүнгээр төсвийг 171.4 сая төгрөгөөр бууруулж тодотгол хийгдсэн байна.

#### **3.6.2 Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд 2,581.9 сая төгрөгийн батлагдсан төсвөөр үйл ажиллагаа явуулж, гүйцэтгэлээр үйл ажиллагаандаа 2,568.0 сая төгрөгийг зарцуулж, төсвийг нийт дүнгээр 13.9 сая төгрөгөөр хэмнэж төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Хэмнэлттэй гарсан зардлууд нь: Цалингийн 0.1 сая, албан томилолтын зардлыг 0.9 сая, үдийн цайны зардлыг 12.9 сая буюу нийт 13.9 сая төгрөгөөр хэмнэсэн байна.

Нийт төсвийн 81 хувийг цалин, 11 хувийг НДШ-ийн зардал, 2.7 хувийг тогтмол зардал, 0.4 хувийг хангамж бараа материалын зардал, 0.1 хувийг норматив зардал, 0.8 хувийг урсгал засварын зардал, 0.1 хувийг бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, 3.9 хувийг бараа үйлчилгээний бусад зардал тус тус эзэлж байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### **3.6.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Засаг даргын нөөц хөрөнгө түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс 0.5 сая, дээд шатны төсвийн захирагчаас 12.3 сая, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлогоос 4.5 сая, нийт 17.3 сая төгрөгийн нэмэлт санхүүжилт хүлээн авсан байна.

Үүнээс хангамж бараа материалын зардалд 0.4 сая, эд хошгил, урсгал засварын зардалд 3.8 сая, бараа үйлчилгээний бусад зардалд 13.1 сая төгрөгийг зарцуулсан байна.

Нэмэлт санхүүжилтийн дансанд хуулиар зөвшөөрөгдөөгүй орлогыг төвлөрүүлээгүй байна. Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### **3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

Ерөнхий боловсролын 5 дугаар сургуулийн 2021 оны санхүүгийн тайланд холбогдох бүх мэдээллийг толилуулж, тодруулсан байна.

АОУС 706.10-д заасан бусад асуудлын хэсэгт тусгахаар аудитын хамрах хүрээний хязгаарлалтын улмаас аудитын хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй байдал үүсээгүй болно.

Өлгий сумын Ерөнхий боловсролын 5 дугаар сургууль нь тайлант онд 2581.9 сая төгрөгийн батлагдсан төсвөөр үйл ажиллагаа явуулж, гүйцэтгэлээр 2568.0 сая төгрөгийг зарцуулсан байна. Үүнээс 2,516.2 сая төгрөг нь байгууллагын үндсэн үйл ажиллагаатай холбоотой цалин, тогтмол зардал, үдийн цайны зардал бөгөөд цалингийн зардлаас 0.1 сая, үдийн цайны зардлаас 12.9 сая төгрөгийг хэмнэж төсөвт төвлөрүүлсэн байна.

Засгийн газрын 2021 озы “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолын хэрэгжилтийг шалгаж үзэхэд тэвчиж болох бусад урсгал зардал 52.7 сая төгрөгийн 10 хувь 5.3 сая төгрөгөөр хэмнэж ажиллах ёстой боловч томилолтын зардлыг 0.9 сая төгрөгөөр хэмнэж төсөвт төвлөрүүлэн, 4.3 сая төгрөгийн хэмнэлт гаргаж ажиллаагүй, тогтоолын хэрэгжилт бүрэн хангагдаагүй гэж үзлээ.

### **3.8 Аудитын гол асуудал**

АОУС 701.8-д тодорхойлсон аудитын гол асуудлын хүрээнд тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэхүйц асуудал гараагүй.

Материаллаг буруу тайлагналын өндөр үнэлэгдсэн эрсдэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал, тайлант хугацаанд гарсан нөлөө бүхий ажил гүйлгээ гараагүй байна.

Аймгийн Засаг даргын 2021 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн А/1075 тоот захирамжаар төсөвт хийсэн зохицуулалтын дагуу Багшийн хөгжлийн танхим ажиллуулахад шаардлагатай техник хэрэгсэл авахад зориулж багаж, техник хэрэгсэл зардлын төсөвт суусан 15.0 сая төгрөгийг сургуулийн захирал “Чарж.” ХХК-тай тоног төхөөрөмж нийлүүлэх 2021 оны 12 дугаар сарын 23-ний өдөр ажлын гэрээ хийж, тус компаний дансанд шилжүүлэн шинээр авлага үүсгэсэн байна. Гэрээнд тоног төхөөрөмжийг 2022 оны 2 дугаар сарын 10-ны дотор нийлүүлэхээр заасан боловч хүлээж аваагүй байна.

### **3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### **3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага нь тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т /шилэн дансны мэдээлэл/ тус тус заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгахад дараах зөрчлүүд илэрлээ. Үүнд:

Шилэн дансны тайлангаар Өлгий сумын Ерөнхий боловсролын 5 дугаар сургуулийн 2021 онд шилэн дансанд оруулбал зохих нийт 119 мэдээллийн 113 мэдээллийг хугацаандаа оруулсан, 2 мэдээллийн оруулах хугацаа болоогүй ба 4 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш зарлагын 31.0 сая төгрөгийн 2 гүйлгээг мэдээлээгүй, 8.0 сая төгрөгийн 1 гүйлгээг хугацаа хоцроож мэдээлсэн, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш нийт худалдан авалтын 31.0 сая төгрөгийн 2 гүйлгээг мэдээлээгүй, авлага үүсгэсэн талаарх 15.0 сая төгрөгийн 1 мэдээллийг оруулаагүй байна.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн дүнгээр 85.0 сая төгрөгийн албан шаардлага өгсөн.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай бүрэн нийцээгүй байна гэж дүгнэлээ

### **3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн бусад хууль тогтоомжийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт нийцсэн байна гэж дүгнэлээ.

### **3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх оны аудитаар цалингийн зардлын төсвийн зарцуулагдаагүй үлдэгдлийг нийгмийн даатгалын шимтгэл, татварт илүү шилжүүлж 2.1 сая төгрөгийн авлага үүсгэсэн зөрчилд албан шаардлага, шилэн дансны мэдээллээс 9 мэдээллийг хугацаа хожимдуулан байршуулсан, цалингийн зардлаас бусад 5.0 сая төгрөгөөс дээш дүнтэй бүгд 97.4 сая төгрөгийн 9 гүйлгээг хугацаа хоцроож мэдээлсэн, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэрийг байршуулаагүй байсан зөрчилд зөвлөмж өгсөн байна.

Өлгий сумын Ерөнхий боловсролын 5 дугаар сургуулийн 2021 оны 06 дугаар сарын 22-ны өдрийн 76 дугаартай албан бичгээр зөвлөмж, албан шаардлагын биелэлтийг ирүүлж, зөвлөмж, албан шаардлагын мөрөөр хийсэн ажлын тайланг шилэн дансанд байршуулсан байна.

Зөвлөмж, албан шаардлагын хэрэгжилтийг давтан шалгаж үзэхэд албан шаардлагын биелэлт хангагдсан, шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй байна.

## 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 90.7 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 89.3 сая төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага, 1.4 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэв.

### 4.1 Залруулсан алдаа

Байхгүй

### 4.2 Төлбөрийн акт

Байхгүй

### 4.3 Албан шаардлага

Аудитаар 89.3 сая төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага өгөв. Үүнд:

1. Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш зарлагын 31.0 сая төгрөгийн дүн бүхий 2 гүйлгээг мэдээлээгүй, 8.0 сая төгрөгийн 1 гүйлгээг хугацаа хоцроож мэдээлсэн, таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 31.0 сая төгрөгийн 2 гүйлгээний худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаягыг оруулаагүй, таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 8.0 сая төгрөгийн 1 гүйлгээний худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаягыг хугацаа хоцроож мэдээлсэн, авлага үүсгэсэн талаарх 15.0 сая төгрөгийн 1 мэдээллийг оруулаагүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.4, 6.4.5, 6.4.8 дахь заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчил арилгуулах талаар албан шаардлага өгөв.

2. Тус 5 дугаар сургуулийн 2021 оны төсвийн төлөвлөлт, зарцуулалтыг Засгийн газрын 2021 озы “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолын дагуу хэрэгжүүлсэн эсэхийг шалгаж үзэхэд тэвчиж болох бусад урсгал зардал 52.7 сая төгрөгийн 10 хувь 5.3 сая төгрөгөөр хэмнэж ажиллах ёстой боловч томилолтын зардлыг 0.9 сая төгрөгөөр хэмнэж төсөвт төвлөрүүлэн, 4.3 сая төгрөгийн хэмнэлт гаргаж ажиллаагүй байна.

Энэ нь Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн Төсвийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.7, 10.1.11-д заасныг үндэслэн гаргасан “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолын 1.1 дэх заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Тэвчиж болох зардлаас хэмнэж зарцуулаагүй 4.3 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага өгөв.

### 4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### 1. Нягтлан бодох бүртгэл хөтлөлт, тайлагналтай холбоотой асуудал

**1.1. Илрүүлэлт:**

Нормативт зардлаас 1.4 сая бараа материалыг орлогод аваагүй, шууд зардлаар бүртгэж тайлагнасан байна.

**1.2. Өгсөн зөвлөмж:**

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3, 14.3.2, 14.3.3, 14.4, 14.4.1 14.4, 14.4.5 дахь заалтуудыг мөрдөж худалдан авсан бараа материалыг орлого авч тооцоо хийх, шууд зардлаар бүртгэж тайлагнасан зөрчлийг арилгах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл**

/сая төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Өлгий сумын Ерөнхий боловсролын 5 дугаар сургууль	3	90.7					2	89.3	1	1.4